



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/178/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2023 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас:70342580 Цахим хаяг: Erdene.B@audit.local Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: П.Мөнхтуяа Утас: 70342716 Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn Аудитор: Утас: 70342716 Цахим хаяг:</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-2580
E-mail:bulgan@audit.gov.mn

2023.02.13 № 43

танай _____ ны № _____ т

АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ДАРГА, ХУРАНДАА Ш.БААСАНДОРЖ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн. Тухайн байгууллагын хувьд тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.2 болон 8 дугаар зүйлийн 8.1 дэх зүйлүүдэд зааснаар тээврийн хэрэгсэл, дүрэмт хувцасны талаарх хязгаарлалтад хамрагдаагүй.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

ОБЕГ-аас 2022 оны 02 дугар сарын 01-ний өдрийн А/20 тоот тушаалаар болон ОБЕГ-ын харьяа 115-р ангийн зарлагын баримт, тооцоо нийлсэн актаар 119.8 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 190.7 сая төгрөгийн тусгай зориулалтын, 2.2 сая төгрөгийн бичиг хэргийн, 19.0 сая төгрөгийн сэлбэг хэрэгслийн, 78.0 сая төгрөгийн шатахуун, 120.6 сая төгрөгийн бусад хангамжийн материалыг тус тус шилжүүлснийг үндсэн хөрөнгийн болон бараа материалын тодруулга тайланд орлого авч бүрэн тайлагнасан байна.

006020047

Бусад асуудлын хэсэг

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр ОБЕГ-тай гэрээ байгуулан 2 зорилтын хүрээнд 14 ажил төлөвлөснөөс, 13 ажил бүрэн хийгдэж 1 ажил дутуу, 98 хувийн гүйцэтгэлтэй.

Аймгийн Засаг даргын 5 зорилтын хүрээнд 25 ажил төлөвлөснөөс 24 ажил нь бүрэн биелэгдэж 1 ажил дутуу, 96 хувиар дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


 Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,142,341,656.92</u>	<u>1,337,883,216.92</u>
33	АВЛАГА	2,331,010.12	2,331,010.12
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	153,370.30	153,370.30
335	Бусад авлага	2,177,639.82	2,177,639.82
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,177,639.82	2,177,639.82
35	БАРАА МАТЕРИАЛ	1,140,010,646.80	1,335,552,206.80
351	Түүхий эд материал	826,482,778.65	1,022,024,338.65
35110	Тусгай зориулалттай материал	826,482,778.65	1,022,024,338.65
354	Хангамжийн материал	307,117,868.15	307,117,868.15
35410	Бичиг хэргийн материал	803,000.00	803,000.00
35420	Аж ахуйн материал	113,527,875.75	113,527,875.75
35430	Сэлбэг хэрэгсэл	723,000.00	723,000.00
35440	Түлш, шатах тослох материал	150,850.00	150,850.00
35450	Барилгын засварын материал	141,000.00	141,000.00
35470	Бусад хангамжийн материал	191,772,142.40	191,772,142.40
35600	Мал амьтад	6,410,000.00	6,410,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,920,636,166.95</u>	<u>4,824,307,497.94</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,920,636,166.95	4,824,307,497.94
392	Биет хөрөнгө	4,623,292,766.95	4,526,964,097.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,726,039,086.27	1,880,805,126.27
39202	Хуримтлагдсан элэгдэл	-480,050,112.37	-566,176,001.02
39203	Авто-тээврийн хэрэгсэл	4,422,244,015.48	4,542,044,015.48
39204	Хуримтлагдсан элэгдэл	-1,086,535,308.66	-1,372,852,302.54
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	385,178,338.20	387,678,338.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-343,630,960.76	-344,570,920.88
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,462,637.09	31,462,637.09
39208	Хуримтлагдсан элэгдэл	-31,414,928.30	-31,426,794.66
39214	Бусад үндсэн хөрөнгө	53,587,729.28	53,587,729.28
39215	Хуримтлагдсан элэгдэл	-53,587,729.28	-53,587,729.28
393	Биет бус хөрөнгө	297,343,400.00	297,343,400.00
39301	Програм хангамж	3,045,000.00	3,045,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,045,000.00	-3,045,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	297,343,400.00	297,343,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>6,062,977,823.87</u>	<u>6,162,190,714.86</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>735,667.28</u>

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	735,667.28
413	Өглөг	00.00	735,667.28
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	735,667.28
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,062,977,823.87	6,062,977,823.87
51	Засгийн газрын хувь оролцоо	6,062,977,823.87	6,062,977,823.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,162,057,121.97	1,162,057,121.97
51101	Өмч: - төрийн	1,162,057,121.97	1,162,057,121.97
512	Хуримтлагдсан үр дүн	3,915,036,654.42	3,915,036,654.42
51210	Өмнөх үеийн үр дүн	3,915,036,654.42	3,915,036,654.42
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	985,884,047.48	985,884,047.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,062,977,823.87	6,063,713,491.15

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,938,564,097.40	3,182,254,069.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	195,269,727.00	532,930,840.00
120	Нийтлэг татварын бус орлого	195,269,727.00	532,930,840.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	195,269,727.00	2,500,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	765,850.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	194,503,877.00	2,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,743,294,370.40	2,649,323,229.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,633,805,400.00	2,443,124,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,633,805,400.00	2,443,124,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	109,488,970.40	206,198,429.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	20,447,170.40	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,399,800.00	11,594,290.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	83,642,000.00	189,870,371.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	4,733,768.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,007,318,343.41	3,083,776,845.29

21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,007,318,343.41	3,083,776,845.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,003,830,993.41	3,073,864,445.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,228,715,250.00	1,833,014,600.00
210101	Үндсэн цалин	728,489,593.00	1,082,944,000.00
210102	Нэмэгдэл	467,555,657.00	687,106,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,670,000.00	62,964,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,946,300.00	61,517,667.28
210201	Тэтгэврийн даатгал	37,296,000.00	52,324,367.28
210202	Тэтгэмжийн даатгал	1,825,200.00	1,861,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,460,400.00	1,489,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	364,700.00	3,593,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	2,248,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,729,439.00	203,952,300.00
210301	Гэрэл, цахилгаан	9,028,607.00	21,779,000.00
210302	Түлш, халаалт	75,005,682.00	181,077,600.00
210303	Цэвэр, бохир ус	695,150.00	1,095,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,068,471.00	22,380,938.00
210401	Бичиг хэрэг	1,037,977.00	4,780,300.00
210402	Тээвэр, шатахуун	44,118,770.00	11,844,038.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,231,124.00	3,333,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,680,600.00	2,423,500.00
2105	Нормативт зардал	100,258,645.00	198,822,680.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	27,456,550.00	10,878,200.00
210502	Хоол, хүнс	44,904,250.00	67,904,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	27,897,845.00	120,039,780.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	126,378,532.90	128,133,051.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,138,990.00	1,896,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	20,158,100.00
210604	Урсгал засвар	125,239,542.90	106,078,351.00
2107	Томилолт, зочны зардал	80,667,500.00	68,730,100.00
210702	Дотоод албан томилолт	80,667,500.00	68,730,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,260,395.00	44,999,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,769,130.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	412,500.00	1,116,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	37,041,800.00	34,938,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,652,865.00	1,834,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,197,015.00	3,856,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,580,970.00	1,670,100.00
210807	Газрын төлбөр	606,115.00	1,583,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	245,806,460.51	512,314,109.01

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	90,831,834.00	128,856,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,035,667.00	10,063,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	149,938,959.51	373,394,709.01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,487,350.00	9,912,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,487,350.00	9,912,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,487,350.00	9,912,400.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-68,754,246.01</u>	<u>98,477,223.71</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-68,754,246.01</u>	<u>98,477,223.71</u>

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,744,060,220.40</u>	<u>2,649,323,229.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	765,850.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	765,850.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	765,850.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	765,850.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>1,743,294,370.40</u>	<u>2,649,323,229.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,633,805,400.00	2,443,124,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,633,805,400.00	2,443,124,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	109,488,970.40	206,198,429.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	20,447,170.40	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,399,800.00	11,594,290.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	83,642,000.00	189,870,371.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	4,733,768.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,711,339,934.90</u>	<u>2,494,557,189.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>1,711,339,934.90</u>	<u>2,494,557,189.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>1,707,852,584.90</u>	<u>2,484,644,789.00</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,228,715,250.00	1,833,014,600.00

210101	Үндсэн цалин	728,489,593.00	1,082,944,000.00
210102	Нэмэгдэл	467,555,657.00	687,106,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,670,000.00	62,964,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,946,300.00	60,782,000.00
210201	Тэтгэврийн даатгал	37,296,000.00	51,588,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,825,200.00	1,861,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,460,400.00	1,489,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	364,700.00	3,593,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	2,248,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,729,439.00	203,952,300.00
210301	Гэрэл, цахилгаан	9,028,607.00	21,779,000.00
210302	Түлш, халаалт	75,005,682.00	181,077,600.00
210303	Цэвэр, бохир ус	695,150.00	1,095,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,971,501.00	20,195,438.00
210401	Бичиг хэрэг	1,037,977.00	2,594,800.00
210402	Тээвэр, шатахуун	25,201,800.00	11,844,038.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,231,124.00	3,333,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,600.00	2,423,500.00
2105	Нормативт зардал	45,210,800.00	78,782,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	306,550.00	10,878,200.00
210502	Хоол, хүнс	44,904,250.00	67,904,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	146,315,732.90	162,675,051.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	21,076,190.00	54,689,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	20,158,100.00
210604	Урсгал засвар	125,239,542.90	87,827,351.00
2107	Томилолт, зочны зардал	80,667,500.00	68,730,100.00
210702	Дотоод албан томилолт	80,667,500.00	68,730,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,260,395.00	44,999,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,769,130.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	412,500.00	1,116,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	37,041,800.00	34,938,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,652,865.00	1,834,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,197,015.00	3,856,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,580,970.00	1,670,100.00
210807	Газрын төлбөр	606,115.00	1,583,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,035,667.00	11,513,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,450,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,035,667.00	10,063,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,487,350.00	9,912,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,487,350.00	9,912,400.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,487,350.00	9,912,400.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>32,720,285.50</u>	<u>154,766,040.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,399,600.00	154,766,040.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,399,600.00	154,766,040.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,399,600.00	154,766,040.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,399,600.00	154,766,040.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-5,399,600.00</u>	<u>-154,766,040.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	27,320,685.50	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	27,320,685.50	00.00

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00

C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,162,057,121.97	985,884,047.48	3,915,036,654.42	00.00	6,062,977,823.87
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,162,057,121.97	985,884,047.48	3,915,036,654.42	00.00	6,062,977,823.87
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,162,057,121.97	985,884,047.48	3,915,036,654.42	00.00	6,062,977,823.87
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	96,712,890.99	00.00	96,712,890.99
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,162,057,121.97	985,884,047.48	4,011,749,545.41	00.00	6,159,690,714.86

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,443,124,800.00	2,443,124,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,443,124,800.00	2,443,124,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,438,252,400.00	2,438,252,400.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,833,014,600.00	1,833,014,600.00
210101	Үндсэн цалин	1,082,944,000.00	1,082,944,000.00
210102	Нэмэгдэл	687,106,600.00	687,106,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	62,964,000.00	62,964,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,782,000.00	60,782,000.00

210201	Тэтгэврийн даатгал	51,588,700.00	51,588,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,861,600.00	1,861,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,489,500.00	1,489,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,593,700.00	3,593,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,248,500.00	2,248,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	203,952,300.00	203,952,300.00
210301	Гэрэл, цахилгаан	21,779,000.00	21,779,000.00
210302	Түлш, халаалт	181,077,600.00	181,077,600.00
210303	Цэвэр, бохир ус	1,095,700.00	1,095,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,851,400.00	11,851,400.00
210401	Бичиг хэрэг	2,594,800.00	2,594,800.00
210402	Тээвэр, шатахуун	3,500,000.00	3,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,333,100.00	3,333,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,423,500.00	2,423,500.00
2105	Нормативт зардал	71,582,900.00	71,582,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,878,200.00	10,878,200.00
210502	Хоол, хүнс	60,704,700.00	60,704,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	203,435,700.00	203,435,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,089,600.00	7,089,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	20,158,100.00	20,158,100.00
210604	Урсгал засвар	176,188,000.00	176,188,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,431,100.00	1,431,100.00
210702	Дотоод албан томилолт	1,431,100.00	1,431,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,999,000.00	44,999,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,116,000.00	1,116,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	34,938,900.00	34,938,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,834,100.00	1,834,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	3,856,500.00	3,856,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,670,100.00	1,670,100.00
210807	Газрын төлбөр	1,583,400.00	1,583,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7203400.00	7203400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	400,000.00	400,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,803,400.00	6,803,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4872400.00	4872400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,872,400.00	4,872,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,872,400.00	4,872,400.00

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	00.00	2,443,124,800.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	2,443,124,800.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	00.00	2,443,124,800.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01	01
610001	Төсвийн байгууллага	01	01
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	128.00	128.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	103.00	103.00
620003	Үйлчлэх ажилтан	24.00	24.00

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	206,198,429.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	206,198,429.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	201,158,429.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,344,038.00
210402	Тээвэр, шатахуун	8,344,038.00
2105	Нормативт зардал	7,200,000.00
210502	Хоол, хүнс	7,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	114,005,391.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	52,600,000.00
210604	Урсгал засвар	61,405,391.00
2107	Томилолт, зочны зардал	67,299,000.00
210702	Дотоод албан томилолт	67,299,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4310000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,050,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,260,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5040000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,040,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,040,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	206198429.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	206,198,429.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,594,290.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	189,870,371.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,733,768.00
131106	Төсвийн урамшуулал	00.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Булган аймгийн Онцгой байдлын газар нь Монгол Улсын хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, түүх соёлын үнэт зүйлсийг гамшгаас хамгаалах, болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, хүч хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлэх, олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, гамшиг судлалыг хөгжүүлэх замаар үндэсний аюулгүй байдал, улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, иргэдийг аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Гамшгаас урьдчилан сэргийлэх тэмцэх хойшлуулшгүй сэргээх босгох, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж дэмжлэг үзүүлэх, шуурхай хариу авах үйл ажиллагаа явуулж байна.

Тухайн жил ОБЕГ-тай 2022 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөний гэрээ байгуулан 2 зорилтын хүрээнд 14 ажил төлөвлөснөөс 13 ажил бүрэн хийгдэж, 1 ажил дутуугаас биелэлт 98, аймгийн Засаг даргын 5 зорилтын хүрээнд 25 ажил төлөвлөснөөс 24 ажил нь бүрэн биелэгдэж, 1 ажил дутуу хийгдэн, 96 хувиар тус тус дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай, Ойн тухай, Улсын онцгой комиссын албан даалгавар, ЕГ-ын тушаал, шийдвэр, Шадар сайдын тушаал болон стандарт дүрэм журмыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй, ОБЕГ-ын 2016 онд батлагдсан НБББББ мөрдөж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй /үр нөлөөгүй байна.

Дотоод хяналттай холбоотойгоор харилцагч байгууллага хувь хүмүүстэй тооцоо нийлж ажиллаагүй. байгууллагын жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг чанартай үр дүнтэй хийсэн эсэхийг шалгахад горим хэрэгжүүлсэн. Горим сорилоор тооллогын баримт материалтай танилцахад байгууллагын даргын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/89 тоот тушаалаар тооллогын 6 комисс томилж ажилласан байна.

Тухайн жилд үндсэн хөрөнгө болон бараа материал актлаагүй, хөдөлгөөн хийгдээгүй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Онцгой байдлын газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь ОБЕГ 2016 оны 12 дугаар сарын 15 –ны өдрийн А/293 тоот тушаалаар НБББББ-ыг батлан гаргасан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг шинэчлэн батлаагүй 2016 онд баталсан НБББББ-ыг мөрдлөг болгосон байна..

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 96.7 сая төгрөгөөр буюу 1.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	2331.0	2331.0	0
Бараа материал	1140010.6	1335552.2	195541.6
Үндсэн хөрөнгө	4920636.1	4821807.5	-98828.6
Нийт хөрөнгө	6062977.8	6159690.7	96712.9
Өр төлбөр	0	735.7	735.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1162057.1	1162057.1	0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6062977.8	6063713.5	735.7

Дээрх хүснэгтээс харахад бараа материал өмнөх оны үзүүлэлтээс 195541.6 мянган төгрөгөөр өсөж, үндсэн хөрөнгө 98828.6 мянган төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2621.3 сая төгрөгөөр нийт зарлагыг 2621.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт зардлыг 178.2 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Энэ нь Хутаг-Өндөр суман дахь “Эрэн хайх аврах салбар”-ын 11 орон тоо дутуугаас холбогдох зардал буурсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2443.1 сая төгрөгийг улсын төсвөөс, аймгийн ЗДТГ-ын нөөц хөрөнгөөс 11.6, ОБЕГ-аас 189.9, үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоос 4.7 сая төгрөг буюу нийт 2649.3 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2443.1, ЗДНХ-өөс 11.6, ОБЕГ-аас 189.9 сая төгрөгийн санхүүжилт тус тус авч нийт 2649.3 сая төгрөгийг бүрэн зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2649.3 сая төгрөг буюу 100 хувиар зарцуулжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа	2438252.4	2438252.4	0	100
2	Тэтгэмж урамшууллын үйл ажиллагаа	4872.4	4872.4	0	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Булган аймгийн ЗДНХ-өөс наадам, айргийн баярын хамгаалалтын зардалд 8.8, 2021 оны ажлын үзүүлэлтээр аймгийн хэмжээнд 3-р байр эзэлсэн шагналд 1.6, эрсдэлийн сангаас 5.2 нийт 11.6 сая төгрөгийг, ОБЕГ-аас санхүүжсэн 189.9 сая төгрөгийг 2021 оны 04 дүгээр улирлын, 2022 оны 1-3 улирлын гамшиг ослын томилолтын зардалд, агуулах барилгын дээврийн засварын зардалд, үйл ажиллагааны хүрээнд бий болсон 4.7 сая төгрөгийг Иргэний нисэхийн Ерөнхий газрын Булган аймаг дахь Нисэх буудлын хамгаалалтын зардалд, тэмцээн уралдааны зардалд тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсөл хөтөлбөр хэрэгжээгүй болно.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Тэрбум мод тарих үйл ажиллагаа	2022.04.25-2022.12.31	2 жил	7500 ширхэг үхрийн мод тарихаас 100 хувь буюу бүрэн тарьсан.	83600.0	86000.0

Аймгийн Онцгой байдлын газар нь 2022 онд Тэрбум мод тарих төслийн хүрээнд 83.6 сая төгрөгийн санхүүжилт авч 43.0 сая төгрөгийн 7500 ширхэг үхрийн модны суулгац авч мод тарих үйл ажиллагаанд 86.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн зарцуулалтыг дурдвал: Гүний худаг 14.0, усалгааны систем 13.0, хашааны тор, шон, худгийн байр барих зардлуудад 16, суулгац худалдан авахад 43.0 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 20/13 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүжилтийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүжилтийн дүнгийн 2443128.8 мянган төгрөгөөс 75 хувиар буюу 27485.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль *хамаарахгүй болно.*

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тухайн жилд шилэн дансанд мэдээлэх 181 мэдээнээс 1 мэдээг хугацаа хоцроож, 180 мэдээг хугацаанд нь мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Аймгийн ОБГ нь 2022 оны 03 дугаар сард тэмцээнд оролцох, бэлтгэлд гарсан ажилчдын хоолны зардлыг хамт олны шийдвэрээр дээрх сарын хоолны мөнгийг тооцон зарцуулах болсонтой холбогдуулан цалингийн зардлаас тооцож олгосон боловч 144000.00 /нэг зуун дөчин дөрвөн мянган/ төгрөгийг илүү тооцон цалингийн зардлаас шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4

дэх заалтын 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

Цалингийн зардлын 4.3 сая төгрөгийг тэмцээний бэлтгэл хийж байгаа ажилчдын хоолны зардалд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “зардлын эдийн засгийн ангилал, ашиглах заавар”-ын дагуу зориулалтаар зарцуулах гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага тогтоов.

Нэг удаагийн тэтгэмжийн зардал 3.7 сая төгрөгийг хоолны зардалд шилжүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “зардлын эдийн засгийн ангилал, ашиглах заавар”-ын дагуу зориулалтаар зарцуулах гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага тогтоов.

Хүнсний тайлангийн орлого, зарлагын нарийвчилсан горим сорилоор нярав махны 1850.0 мянган төгрөгийн орлого илүү тайлагнасан. Харилцагч байгууллага хувь хүмүүстэй тооцоо нийлж баталгаажуулаагүй, мөн бараа материалын тодруулга тайлангаар малын эхний болон эцсийн үлдэгдлийг 6410.0 мянган төгрөгийн малтайгаар тайлагнасан нь малын өсөлт, бууралтын хөдөлгөөнийг тайлагнадаггүй, тухайн оны малын А данстай тулгахад 33 төл авснаар тоологдсон, өмнөх жилийн төлийн үнээр тооцвол 965.0 мянган төгрөгийн төл нэмэгдэж бүртгэгдэхийг бүртгээгүй зөрчлүүд илэрсэн нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн

холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/ нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 06 дугаар сарын 1-ний өдрийн 20/117 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0	0
Албан шаардлага	0	0	0	0	0
Зөвлөмж	6	9450.0	6	9450.0	100
Нийт дүн	6	9450.0	6	9450.0	100

/мянган төгрөгөөр/

Хэрэгжээгүй зөвлөмжийг дурдах, шалтгааныг тайлбарлах

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Малын өсөлт, бууралт, орлого, зарлагын зарцуулалт, мөн үндсэн хөрөнгө болон бараа материалын акталж, устгах хөрөнгийн жагсаалт үйлдэн хөдөлгөөнийг цаг хугацаанд нь тайлагнаж ажиллах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 11.7 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 0.7 сая төгрөгийн алдааг залруулж, 2.8 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байхаар 2 зөвлөмж өглөө.

Үүнд: Өглөгийн тайланд 0.7 сая төгрөгийн өглөгийг дутуу илэрхийлсэн.

Аудитаар нийт 11.0 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 0.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 8.0 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 2.8 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Цалингийн зардлаас хоолны зардалд 0.1 сая төгрөгийг илүү шилжүүлсэн зөрчилд төлбөрийн акт тогтоов .

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Албан шаардлага

Цалингийн зардлаас 4.3 сая төгрөгийг хоолны зардалд шилжүүлсэн зөрчилд албан шаардлага тогтоов.

5.3 Албан шаардлага

Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 3.7 сая төгрөгийг хоолны зардалд шилжүүлэн зарцуулсан зөрчилд албан шаардлага тогтоов.

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хүнсний тайланг тулгахад нярав 1.8 сая төгрөгөөр орлого илүү тайлагнасан. Харилцагч байгууллага, хувь хүмүүстэй тооцоо нийлж баталгаажуулаагүй.

Өгсөн зөвлөмж:

НББ-ийн тухай хуулийн 20.2.6 дахь заалтын дагуу харилцагч байгууллага болон хувь хүмүүстэй тооцоо нийлж баталгаажуулж ажиллах

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Малын өсөлт бууралтын хөдөлгөөнийг тооцож тайлагнаагүй 33 төлийн 0.9 сая төгрөгийн төлийн орлогыг тайлагнаж бүртгээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

НББ-ийн тухай хуулийн 13.1, 13.6, 13.7 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж, малын өсөлт, бууралтын хөдөлгөөнийг тооцож бүрэн тайлагнаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өглөгийг дутуу	1	735.7			1	735.7	1	735.7				
Дүн	1	735.7			1	735.7	1	735.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
									Албан тушаалтны тоо			

